


## ШИНЭ НОМ

ШУА-ийн Олон Улс Судлалын хүрээлэнгийн 40 жилийн ой энэ онд тохиож байгаа билээ. Энэ ойг тус хамт олон эрдэм бүтээлийн их амжилтаар угтсан нэгээхэн хэсэг нь эрдэмтэн судлаачдын шинэ номын дээжис болно. Үүнд:

1. Монголын шинжлэх ухааны 108 ботийг Монголын эрдэмтэд уншигч олноо өргөн барьсаны дотор “Монгол дахь олон улс судлал” (УБ, 2008) хэмээх 45-р ботийг манай эрдэмтэн докторууд туурвин бичлээ.  
Эл номд тус хүрээлэнгийн дотоод, гадаад олон талт үйл ажиллагааг тусган, өнөөдөр манай оронд нийгмийн шинжлэх ухааны бие даасан салбар болон хөгжиж буй олон улс судлалын өнөөгийн байдал төлвийг анх удаа нэгтгэн дүгнэсэн томоохон бүтээл болсон юм.
2. Мөн хүрээлэн үүсч байгуулагдсан түүх, эдүгээ хүртэлх 40 жилийн товчоолон бичсэн “Олон улс судлал-40 жил” (УБ, 2008) гэдэг ном уншигч таны ширээн дээр очлоо. Эл номд Ази-Африкийн хэлтэсээс Дорнодахин судлалын хүрээлэн, улмаар Олон улс судлалын хүрээлэн болж өргөжсөн түүхэн замнал хийгээд тус хүрээлэнд ажиллаж байсан үе үеийн эрдэмтэн мэргэдийн товч намтар, тус хүрээлэнгээс эрхлэн гаргадаг сэтгүүлүүдэд хэвлэгдсэн бүтээлийн иж бүрэн жагсаалтыг хамран багтааснаараа чухал ач холбогдолтой юм.
3. Мөн “Монгол Улсын гадаад бодлогод тэргүүлэх байр суурь эзэлдэг орнуудын судалгаа” суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд “БНХАУ-ын хөгжлийн чиг хандлага: амжилт ба сорилт” (УБ, 2008) судалгааны шинэ бүтээлийг тус хүрээлэнгийн Хятад судлалын тасгаас эрхлэн хэвлүүлээ.  
Эл номд Хятад дахь улс төр, нийгмийн бодлогын өөрчлөлт, Хятадын эдийн засгийн хөгжлийн явц, шинэ үе шат, баруун бүс нутгийн хөгжлийн стратеги, тухайлбал Өвөр Монгол, Төвд, Шинжааны нийгэм, эдийн засгийн байдал, XXI зууны эхэн үеийн БНХАУ-ын гадаад бодлого, дипломат үйл ажиллагаа зэрэг өргөн хүрээтэй сэдвийг хамарсанаараа уншигч олны анхаарлыг татаж байна.
4. Түүнчлэн Хятад орон судлал, харьцуулсан орчуулга зүй, аялал жуулчлалын салбарт хамаарах хятад-монгол-англи хэл дээр хадмал “Хятадад жуулчлах нь” (УБ, 2008) ном нь

Хятадын түүх, соёл, хэлийг судлах, Хятадад жуулчлах хэн бүхэнд уншин сонирхоход илүүдэхгүй, оюутан сурагчдад сургалтын материал болох ач тустай ном юм. Эл номыг тус хүрээлэнгийн Хятад судлалын тасгийн дарга доктор, профессор Л.Бэгзжав шавь С.Нандинцэцэгтэй хамтран бүтээжээ.



**БНХАУ-ЫН**  
**ХӨГЖЛИЙН**  
**ЧИГ ХАНДЛАГА:**  
**АМЖИЛТ БА СОРИЛТ**

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

